



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/430

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын баяр наадмын өмнө аймгийн өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэрэлтүүлгийн засварын материал тээвэрлэн ирэх зардалд 1 500 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 1 500 000 төгрөг /Нэг сая таван зуун мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, тээвэрлэж ирэх ажлыг зохион байгуулахыг /Д.Энхболд/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

